

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэвээнлозол	Дугаар	L292
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Төмөрбулаг сум
Төрсөн газар	Төмөрбулаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Бүгсийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨТБ 010
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Бүгсийн хүрээ

Мөнхбат:За ингээд таниас энэ Бүгсийн хүрээний гарал үүсэл, хөгжил байгуулагдсан он цагуудын тухай одоо мэддэг зүйлээ бидэнд хэлж өгнө үү?

Цэвээнлозол: За энэний түүх нь бол одоо номон дээр байж байгаа л даа, угаасаан.Нэг ном бүтээсэн, Батловоо гэж одоо лам, эндхийн ууган шавь гэж байгаа.Аа тэрний бас бодол босгосон тэр лам нь Дамбаа, гортон Дамбаа хүн байсан. Тэр хүн босгосон.Тэр хүн л ер нь гол юмыг нь хийсэн дээ.Тэгээд нутгийн ард түмэн, Бүрэнтогтох , Төмөрбулаг энэ хоёроос хамжиж энийг босгосон, ард иргэд нь.Ийм л юм, энэнээс сүүлд одоо би товч айхтар тэгээд тийм тийм гээд хэлчих түүхийн юм бол би сайн мэдэхгүй л дээ, хойд үеийнх нь юм болохлээр. Бас айхтар айхтар юмнүүд ярьж л байдаг, манай хөгшчүүл.Тэгээд яахав зүгээр, би байж байгаагийн нь хувьд энийг нэг унтраачихгүй шиг л байж байна.Би иймэрхүү л юм ярина.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: За хүрээ хорьдугаар зууны эхэн үеэр буюу 1921 оны ардын хувьсгалын дараа тухайн үеийн нам төрийн явуулсан бодолого шийдвэрийн дагуу монголын буддын шашны хүрээ хийдүүд одоо их хэлмэгдэлтэнд өртсөн.Тэгэхээр энэ хэлмэгдлийн тухай Бүгсийн хүрээ чухам яаж хэлмэгдсэн шатаагдаж , устгагдсан, лам нарыг одоо хэрхэн, лам нарын хувь заяа одоо яаж шийдэгдсэн талар та одоо товч сонссон зүйлээ ярьж өгнө үү?

Цэвээнлозол: За энчээ лам нарыг бол их л хорьж, алж талж яаж байсан юм гэсэн.Тэрийг бол би нэг их сайн тодорхой мэдэхгүй.Хоёр мянган ламтай байсан гэдэг юм байна лээ.Хоёр мянган ламтай, хичнээн ч олон дуган байсан гэдэг юм.Зөндөө л юм байдаг юм гэнэ лээ.Номон дээр байгаа, одоо.

Мөнхбат:Тэгэхээр өнөөдөр та бид хоёрын зогсож байгаа энэ цогчин байгууламж бол хэдийгээр одоо хуучин Бүгсийн хүрээ дээр сэргээгдсэн ч гэсэн, зарим сумдын нутагт байдаг, манай орны зарим нутагт байдаг хуучин дуган сүм хийдийн түүрийг бодоход бас одоо нэлээн хүч хөдөлмөр гаргаад, нэлээн хөрөнгө бас зарцуулаад одоо хуучнаар нь сэргээн босгохыг эрмэлзсэн нь одоо энэ байдлаас нь харагдаж байна.Гэхдээ харамсалтай нь өнөөдөр одоо энд шашин номын үйл ажиллагаа бараг зогссон байна, тийм ээ?

Цэвээнлозол:Тийм.

Мөнхбат: Тэгэхээр одоо таны бодлоор энд байдаг, энэ сүм дуганыхаа гал голомтыг харж үлдсэн таны хувьд чухам яагаад энд одо хүрээ хийдийн үйл ажиллагаа тогтмол явуулж болохгүй байна гэж үзэж байна вэ?

Цэвээнлозол: Үгүй ээ, би бол одоо энэ зах зээлтэй л холбоотой.Тэгээд хүний маань ухамсар, энэ лам нар маань эрт үеэс одоо бэлтгэгдээгүй боловсрол нь бас дутуу байгаа юм болов уу даа.Тэгээд энийгээ яах дээр аяндаа тосоод яагаад авах байх гэж би бодож байгаа.Тэгээд хойшдоо хүүхдүүд сургая болгоё гээд л манай хойд лам нар ч тэгж ярьдаг юм байна лээ.

Мөнхбат:Тэр цагийг л хүлээж байгаа?

Цэвээнлозол:Тэр цагийг л хүлээж байна.Тэгээд одоо миний нас хүрэх юм болов уу, үгүй юм болов уу, хойшид нь бас энийг хадгадлах ,залгамжлах үлсүүд гарч ирээсэй л гэж бодож байна.

Мөнхбат: За баярлалаа.Таны өгсөн энэ мэдээлэл монголын түүх соёлын дурсгалыг сэргээх, 1937 онноос өмнө байсан сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа.Танд баярлалаа.